

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Нэг. Ерөнхий нөхцөл

- 1.1. Энэхүү бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөл нь (цаашид “БҮЕН” гэх)-ийг “Титан Си Ар Эй Зээлийн мэдээллийн сан” ХХК-ийн (цаашид Үйлчилгээ үзүүлэгч гэх)-ийн зээлийн мэдээллийн үйлчилгээнд дагаж мөрдөнө.
- 1.2. Үйлчилгээ үзүүлэгчтэй “Хэрэглэгчийн гэрээ” байгуулсан хэрэглэгч нь БҮЕН-ээс өөрт тохирсон нөхцлийг сонгоно.
- 1.3. Хэрэглэгч нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан зорилгоор зээлийн мэдээллийн сангийн бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглана.

Хоёр. Зээлийн мэдээллийн бүтээгдэхүүн үйлчилгээ

- 2.1. Хэрэглэгч нь дараах бүтээгдэхүүн үйлчилгээнээс сонгон ашиглана:

№	Бүтээгдэхүүн үйлчилгээний нэр	Тайлбар	Загвар
1.	Стандарт лавлагаа /Standard/	Сүүлийн 6 жилийн зээл төлбөрийн түүхчилсэн лавлагаа	Хавсралт 1
2.	Плас лавлагаа /Plus/	Стандарт лавлагаа болон Хамтран зээлдэгчийн лавлагаа	Хавсралт 2

Гурав. Бүтээгдэхүүн үйлчилгээний хөлс

- 3.1. Үйлчилгээ үзүүлэгчийн нэгж бүтээгдэхүүн үйлчилгээ дараах хөлстэй байна:

№	Бүтээгдэхүүн үйлчилгээний нэр	Бүтээгдэхүүн үйлчилгээний хөлс
1.	Стандарт лавлагаа /Standard/*	1,000 төгрөг
2.	Плас лавлагаа /Plus/*	1,000 төгрөг

*Зээлдэгч нь зээлийн мэдээллийн сангаас өөрийн зээлийн лавлагааг жилд нэг удаа үнэ төлбөргүй авах эрхтэй

Дөрөв. Төлбөрийн нөхцөл

- 4.1. Хэрэглэгч дараах төлбөрийн нөхцлөөс аль нэгийг нь сонгох ба тухайн сонгосон төлбөрийн нөхцлийг “Хэрэглэгчийн гэрээ”-нд тусгана:

№	Төлбөрийн нөхцөл	Тайлбар
1.	Шууд төлбөрт нөхцөл	Иргэн, хуулийн этгээд өөрийн лавлагааг авах
2.	Урьдчилсан төлбөрт нөхцөл	Хэрэглэгчийн гэрээ байгуулсан мэдээлэл нийлүүлэгч, зээлдүүлэгч
3.	Дараа төлбөрт нөхцөл	

- 4.2. Иргэн, хуулийн этгээд өөрийн зээл, төлбөрийн лавлагааг авах үедээ шууд төлбөрийн нөхцлөөр энэ БҮЕН-ийн 4.5-д заасан сувгаас сонгон төлбөр төлж, үйлчилгээ авна.
- 4.3. Урьдчилсан төлбөрт нөхцлөөр төлбөрөө төлж буй хэрэглэгч нь энэ БҮЕН-ийн 4.5-д заасан сувгаас сонгон төлбөрийг шилжүүлэн “SAINSCORE” мэдээллийн систем дэх өөрийн дансыг урьдчилан цэнэглэх бөгөөд үйлчилгээний төлбөр нь систем дэх тухайн цэнэглэсэн данснаас хасагдан төлөгдөнө.

- 4.4. Дараа төлбөрт нөхцлөөр төлбөрөө төлж буй хэрэглэгч нь өөрийн авсан бүтээгдэхүүний нэхэмжлэлийг сар бүрийн 5-ны өдрийн дотор “SAINSCORE” мэдээллийн системд өөрийн эрхээр хандан хянах бөгөөд сар бүрийн 20-ны өдрийн дотор энэ БҮЕН-ийн 4.5.1-д заасан үйлчилгээ үзүүлэгчийн харилцах дансны аль нэгэнд шилжүүлнэ.
- 4.5. Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрийг дараах сувгуудаас сонгон төлнө:
- 4.5.1. Банкны харилцах данс:

Банкны нэр	Дансны дугаар
ХААН банк	5115120482
Голомт банк	8115103097
Худалдаа хөгжлийн банк	418028433
Төрийн банк	341303478960
Хас банк	5004908338
Богд банк	8100003565
Капитрон банк	305505151594

- 4.5.2. QPay үйлчилгээ;
- 4.5.3. Social pay үйлчилгээ;
- 4.5.4. Хаан банкны карт;
- 4.5.5. Худалдаа хөгжлийн банкны карт.
- 4.6. Хэрэглэгч гүйлгээ хийх үед үйлчилгээ үзүүлэгчийн нэхэмжлэл дэх мэдээллийн дагуу гүйлгээний утгыг алдаагүй бөглөнө.

Тав. Хөнгөлөлтийн нөхцөл

- 5.1. Дараа төлбөрт хэрэглэгчид тухайн сард авсан нийт лавлагааны тоонд харгалзах хөнгөлөлтийг дараах байдлаар сар бүр тооцон олгоно:

Нийт лавлагааны тоо (хуанлийн 1 сард)	0-999 ширхэг	1,000-4,999 ширхэг	5,000-14,999 ширхэг	15,000-29,999 ширхэг	30,000-аас дээш
Хөнгөлөлт тооцох хувь	0%	10%	15%	20%	25%

- 5.2. Өмнөх сарын үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд дараа сарын үйлчилгээний төлбөрт энэ БҮЕН-ийн 5.1-т заасан хөнгөлөлтийг олгохгүй.
- 5.3. Энэ БҮЕН-ийн 5.1-д заасан хөнгөлөлтийг тооцоходоо нэгж “Стандарт лавлагаа”-г 1, нэгж “Плас лавлагаа”-г 1 лавлагаанд тус тус тооцно.
- 5.4. Хэрэглэгч нь зээлийн мэдээллийн лавлагааны хөлсийг төлж авснаас хойш 72 (Далан хоёр) цагийн дотор 3 (Гурав) хүртэл удаа үнэ төлбөргүй авч болно.